

- Улсын хилээр нэвтрүүлэх үед үүсэх зорчигч, тээврийн хэрэгслийн бөөгнөрөл “Өнөөгийн хэрэгцээг хийлийн боомтуудын дийлэнх хувь нь нэвтрүүлэх хүчин чадлын хувьд хангахгүй байгаагаас албаны үйл ажиллагаа, шалгалтын тоног төхөөрөмжийн хоцрогдол, боомтын бүтэц, орон тооны хүрэлцээгүй байдал зэргээс бөөгнөрөл үүсэх болсон ”

- Хил хяналтын байгууллагуудын үйл ажиллагааны доголдол буюу хүнд суртал "Байгууллагууд нь босоо удирдлагын тогтолцоотой, харилцан уяалдаа холбоогүй, зарим тохиолдолд зөрчилтэй байгаа зэргээс харагдаж байна"

- Хилийн боомтын зарим барилга байгууламж, дэд бүтэц хараат болсон "Цахилгааны эх үүсвэр, зам харгуй, бусад дэд бүтцийн асуудлыг төр өөрөө бус бизнесийн үйл ажиллагаа явуулдаг компаниудад даатгадаг, хамааралгүй байх тэр боломжийг бүрдүүлж өгч чадахгүй байна ”

Энэ бүхнээс дүгнэхэд дэлхийн улс орны хилийн боомтууд ачааллыг хэрхэн яаж зохицуулж байна, шалган нэвтрүүлэх алба ачааллыг яаж шуурхай нэвтрүүлж байгаа болон ямар орчин үеийн техник, технологийг ашиглаж байгааг судлах, үр дүн нь манай улсын хилийн боомтыг дэлхийн жишигт хүргэх арга замыг олох, хөрш орны хилийн боомтын хүчин чадалд хүргэх үндсэн гол шаардлага гарч байна.

Иймд Хилийн шалган нэвтрүүлэх албыг Хил хамгаалах ерөнхий газарт шилжүүлэн чадвартай, мэргэжилтэй хүний нөөцөөр бэхжүүлэх шаардлагатай гэж судлаачийн хувьд дүгнэж байна.

ХСИС-ийн Хууль сахиулахын удирдлагын
академийн 821 дүгээр дамжааны сонсогч,
дэд хурандаа Г.Энхтүвшин

ХИЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХАД ТУСГАЙ САЛБАРЫН ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЭХ ЗАРИМ АСУУДАЛ

Хураангуй. Дэлхий дахинд болж улс хоорондын тэмцэл нь Монгол Улсын хувьд шууд бус аюул юм. Энэхүү сөргөлдөгч талуудтай манай хил залгаа улсууд холбогдож байгаа нь бид бүхнээс анхаарахгүй байж боломгүй үзэгдэл юм. Манай улсын хувьд гаднаас орж ирэх уламжлалт бус аюултай тэмцэхэд бэлэн үү, ямар хүч хэрэгсэлийг бид ашиглах вэ? гэсэн асуудал чухлаар тавигдаж байна.

Түлхүүр үгс. Хилийн аюулгүй байдал, тусгай салбар

2010 онд батлагдсан Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд оршин тогтнохын аюулгүй байдлын үндэс нь “Монгол

Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, хил хязгаарын халдашгүй байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал” гэжээ.

Аюулгүй байдлыг сахих үйл ажиллагаа нь нийгэмд зэвсэгт хүчин, хил хамгаалах алба, цагдаа, хамгаалалтын болон онцгой байдлын албаны зэрэг тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагын бүтцийг буй болгон, улмаар бүхэлдээ дэлхий ертөнцийн нийт хүн амын аюулгүй байдлыг хангах үүрэгтэй НҮБ-ыг байгуулахад хүргэсэн байна. Аюулгүй байдлын тогтолцоо “хэврэг” сул байх нь улс орон задрах, үндэстэн ястан устгах, цус урсгасан зөрчил, мөргөлдөөн үүсэх, материаллаг үнэт зүйлс эвдрэн сүйдэх зэрэг гай гамшигт хүргэнэ.

Иймээс өнөөгийн бодит байдал дээр Монгол Улс тэр дундаа хилийн аюулгүй байдалд ямар байгаа талаар цухас дурдъя.

Монгол Улс нь геополитик стратегийн байршил талаасаа авч үзвэл ОХУ, БНХАУ-ын хооронд байрласан, эдгээр улс нь дэлхийн бодлогыг тодорхойлдог цөмийн зэвсэгтэй, НҮБ-ийн аюулгүйн зөвлөлийн байнгын гишүүн, хүн ам, нутаг дэвсгэр хэт том хоёр гүрний дунд, соёл иргэншил шашин талаасаа хоёулаа өнө эртний түүх соёлтой буддын-христосын-лалын гэсэн дэлхийн гурван том шашны уулзвар дээр оршдог бөгөөд бүс нутгийн аюулгүй байдлын орчинд таагүй өөрчлөлт гарахад, дотоод улс төрийн байдал хурцдах, үндэсний эв нэгдэл, нэгдмэл байдалд нь заналхийлэх хүчин зүйлс их биш ч үгүйсгэж боломгүй хэмжээнд байна. Манай улсын хувьд өөрийн аюулгүй байдлыг хангахад нэн түрүүнд улсын хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах нөхцөл бүрдүүлэхийг шаардаж байгаа бөгөөд өнгөрсөн үеийн түүхэн сургамж харуулж байна.

Хүн ам, суурин соёл иргэншил төврүү тэмүүлэх нүүдэл ихсэн олонх нь нийслэлд амьдрах болж хил орчмын нутаг дэвсгэр эзэнгүйрч эхлэв. Экологийн нөхцөл байдалд нүүрлэж буй цөлжилт говийн бүсийг төдийгүй тал хээр, ойт хээрийн бүс нутгийг хамарч байгаагаас хүн амын амьдрал ахуйд нөлөөлж, хилийн дагуу асар уудам газар улам эзэнгүйрч улсын хил хамгаалалтад шууд нөлөөлөх болов.

Тэгвэл Хил хамгаалах байгууллага, ХХЕГ-ын даргын бэлтгэл хучний тусгай анги, /салбар/ямар үүрэг оролцоонтой вэ?

Хил хамгаалах байгууллага Хууль зүйн сайдын эрхлэх асуудлын хүрээнд үйл ажиллагаа явуулж, Монгол Улсын Үндсэн хууль, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Гадаад бодлогын үзэл баримтлал, Төрөөс хилийн талаар баримтлах бодлого зэрэг баримт бичгийг удирдлага болгон 1962 оны Монгол-Хятадын хилийн гэрээ, 2011 оны Монгол-Хятадын хилийн дэглэмийн гэрээ, 1958, 1976 Монгол-Оросын хилийн

гэрээ, 2006 оны Монгол-Оросын хилийн дэглэмийн гэрээ, хилийн асуудлаар байгуулсан хэлэлцээр, Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар батлагдсан “Монгол Улсын хил хамгаалалтын дүрэм”, “Улсын хил хамгаалалтад иргэдийг оролцуулах журам”, бусад хууль тогтоомжийг хэрэгжүүлдэг.

Монгол Улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангах, хилийн зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох, хил дээр гарсан өдөөн хатгалгатай тэмцэх, улсын хил дээр улс төрийн болон эдийн засгийн ашиг сонирхолыг хамгаалах цэрэг улс төрийн ач холбогдол бүхий зорилго хүлээсэн байгууллага бол хил хамгаалах байгууллага юм.

Хилийн тусгай анги /салбар/ нь “ХХЕГ-ын даргын бэлтгэл хүч” нэртэйгээр 2010 онд байгуулагдсан. Одоогоор хүн хүч, материал хэрэгсэл, хангалт, ахуй орчин тохижилтын хувьд нилээд сайн бэхжсэн ч үндсэн үйл ажиллагаа болох сургалт бэлтгэлийн үүргээ төдийлөн хангалттай биелүүлж чадахгүй байна гэж судлаачийн хувьд үзэж байна. Энэ нь сургалт, дадлага, албан үүрэг гүйцэтгэх явцад зарим алба хаагчдад ажлын ачаалал хэт их байдгаас алба хаагчдын албанд хандах хандлага сулрах, ажлын бүтээмж буурах зэрэг шалтгаанаас цэргийн алба хаагчдын шилжилт хөдөлгөөн их байна.

Тиймээс Тусгай анги /салбар/-ын бүтэц, удирдлага зохион байгуулалтыг дахин нягтлаж, тодорхой зохион байгуулалттай ажил үүргийн давхардалгүй байх нь нэн тэргүүний чухал сайжруулах үндсэн асуудал болж байна. Энэ бүгдээс харахад шинжлэх ухааны үүднээс нарийн тооцоо судалгаатай бүтэц орон тоог хийх зайлшгүй шаардлага гарч байна. Тусгай анги /салбар/-д ирж ажиллах алба хаагчдыг нарийн шалгуураар сонгон авч шалгаруулалтыг нээлттэйгээр зарлан аль болох өргөн хүрээг хамруулан шалгаруулах нь илүү үр дүнтэй.

Тусгай анги /салбар/ нь *болзошгүй аюулд урьдчилан бэлтгэгдэж өөрсдийн үүрэг гүйцэтгэх боломжийг тодорхойлон, бэлэн байх явдал юм.* Тусгай салбарыг цагийн байдлын ямарч нөхцөлд, тогтоосон хугацаанд өгөгдсөн үүргийг биелүүлэх цэргийн /хүчний/ чадварыг илэрхийлж байгаа тооны ба чанарын үзүүлэлтийн цогц гэж авч үзэж болохоор байна. Чадавх нь хүч чадлыг, чадвар нь оюуны болоод биеийн ажиллах хүч чадлыг, боломж нь хүнээр авч үзвэл түүний хийж гүйцэтгэж болох ажил, өөрөөр хэлбэл түүний ажлынх нь үр дүнг илэрхийлж байна.

Иймээс зэвсэгт халдлагын *чадавхи* гэдэг ойлголтын дор “ХХЕГ-ын даргын бэлтгэл хүчний тусгай салбарын зэвсэглэл техникийн хүчин чадал /ТТӨ/-ыг хэлэх бол, *байлдах чадвар* гэдэг ойлголтын дор “Зэвсэгт халдлагын ажиллагааны явцад ХХЕГ-ын даргын бэлтгэл хүчний тусгай

салбарын зэвсэглэл, тсхникийн /бие бүрэлдэхүүний сургалт, бэлтгэл, зэвсэглэл, техникийн хүчин чадал/ дайсанд учруулах хөнөөлийн хэмжээ”-г хэлэх бол, *зэвсэгт халдлагын боломж* гэдэг ойлголтын дор “Зэвсэгт халдлагын төгсгөлд зэвсэгт халдлагын чадавхыг ашиглаж хүрсэн буюу гаргасан үр дүнг байлдах чадвараар илэрхийлсэн байдал”-ыг гэж ойлгож болно.

Нөгөө талаас зэвсэгт халдлагын боломж нь байлдах чадвараар, чадвар нь зэвсэгт халдлагын чадавхаар тодорхойлогдоно. Зэвсэгт халдлагын боломжийг тодорхойлоход харгалзан үзвэл зохих хүчин зүйлийг дараах байдлаар авч үзнэ:

- Цэрэг, техникийн хүчин зүйл;

Тусгай салбарын удирдлага болон бие бүрэлдэхүүний бэлтгэлжилтийн хүчин зүйл;

- Тодорхой цагийн байдлын хүчин зүйл

Боломжид нөлөөлөх хүчин зүйлсийг авснаар зэвсэгт халдлагын боломжийг тодорхойлогч үзүүлэлтүүдийг бодитоор тооцох боломжтой болно. Гал, цохилт нягт хамтран хэрэгждэг бөгөөд сүүлийн үеийн дайн, зэвсэгт халдлагын ажиллагаанд дүгнэлт хийж үзвэл дайн, зэвсэгт халдлагын ажиллагааны үндсэн хэсгийг цохилтын боломжоор шийдвэрлэх болсон. Яагаад цохилтын хүчээр шийдвэрлэх болов гэвэл цохилт нь галын хөнөөлтэй нягт холбогдсон, хөнөөлийн хэрэгслээр дамжин хийгдэж байгаад оршиж байна гэж үзэж болно.

Эдгээрээс үндэслэн хэрэгцээ шаардлагыг тайлбарлах нь илүүц тул хилийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээг шинэ шатанд гаргаж хууль тогтоомжид шинэчлэн өөрчлөх, хилийн аюулгүй байдлын албаны ажилтнуудыг сургах, бэлтгэх, технологийг сайжруулах, бэлэн байдал, ажиллагааны далайцыг эрчимжүүлэх гэх мэт олон талт арга хэмжээг цогцоор нь авч хэрэгжүүлэх нь зүйтэй юм.

Сүүлийн жилүүдэд Монгол Улсын эдийн засгийн чадавх тогтворгүй байгаа нь хилийн цэргийн анги нэгтгэлүүдийн зэвсэглэл техникийн шинэчлэл удааширч цэргийн нөөцийн байдал нилээд хүнд байдалд байна гэж үзэж байна.

Хэдийгээр эдийн засгийн байдал муу байгаа ч болзошгүй аюулд өөрийн улсыг урьдаас бэлтгэх нь хойшлуулшгүй асуудал бөгөөд ХХЕГ-ын бэлтгэл хүчинд үүрэг гүйцэтгэх тусгай салбарын байлдах чадвар, байлдааны боломжийг онолын хувьд тооцохдоо зэвсэглэл, техник, бие бүрэлдэхүүний бэлтгэлжилтийг бодитойгоор гаргаж (*хэлбэр төдийд биш*) мэргэжлийн чадварлаг байнгын сургалт, бэлтгэлээр хангагдсан бүрэлдэхүүнийг бэлэн байдалд байлгах шаардлага урган гарч байна.

Эцэст нь дүгнэхэд ХХЕГ-ын даргын бэлтгэл хүчний тусгай салбарыг ангийн зохион байгуулалтанд шилжүүлж бүтэц, удирдлага зохион байгуулалтыг дахин хийж тусгай үүргийн сургалтуудыг нарийн төлөвлөлт зохион байгуулалттайгаар явуулснаар өндөр бэлтгэлтэй болзошгүй аюулыг устгах чадвар бүхий хүнтий нөөц бэлтгэгдэх боломжтой байна.

Олон улсын тусгай албадууд болон түргэн байрлах хүчинд ашиглагдаж байгаа техник хэрэгсэл, өндөр цэцтэй буу, нисдэг тэрэг болон бусад төрлийн зэвсэглэлээр хангах шаардлагатай.

*ХСИС-ийн Хууль сахиулахын удирдлагын
академийн суралцагч,
дэд хурандаа Д.Амархүү*

ХИЛ ХАМГААЛАХ БАЙГУУЛЛАГАД ИННОВАЦИЙН МЕНЕЖМЕНТИЙГ НЭВТРҮҮЛЭХ НЬ

Хураангуй. Энэхүү илтгэлээр хил хамгаалах байгууллага түүний бодлого, үйл ажиллагаа /хил хамгаалалт/-нд инновацийн менежментийг хэрхэн нэвтрүүлэх тухай асуудлыг хөндлөө.

Тулхүүр үг. Инноваг/и, инновацийн менежмент, хил хамгаалах байгууллага, инновацин стратеги

Өнөө үед дэлхий дахины улс орны нийгэм, эдийн засгийн хөгжлийн гол хөдөлгөгч хүч нь үндэсний инновацийн тогтолцоог бүрдүүлэх явдал болсон бөгөөд мэдлэг оюуны үнэ цэнэ үлэмж нэмэгдэн газар, капитал, хөдөлмөрийн нэгэн адил эдийн засгийн нөөц үйлдвэрлэлийн чухал хүчин зүйлийн үүрэг гүйцэтгэх болж, түүнд тулгуурласан инновацийн эдийн засаг бүрэлдэн тогтох үйл явц эрчимтэй өрнөж байна.

Дэлхийн өндөр хөгжилтэй орнууд шинэ техник, технологийн салбарт өндөр ач холбогдол өгч, төрийн шууд оролцоотойгоор энэ чиглэлийн инкубатор, технопарк, технополис, аж үйлдвэрийн парк, инновацийн төвийг байгуулж байна.

Энэ талаар төр засгаас эхлэлийн тодорхой алхам хийгдэж байгаагийн нэг бол Монгол Улсын инновацийн төвшний үнэлгээг хийх, инновацийн эрх зүйн орчныг бүрдүүлж Монгол Улсын шинжлэх ухаан, технологийн талаар төрөөс баримтлах бодлого /1998/, Инновацийн тухайн хууль, Шинжлэх ухаан, технологийг 2007-2020 онд хөгжүүлэх мастер